



МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН  
ТУШААЛ

2020 оны 03 сарын 12 өдөр

Дугаар А/122

Улаанбаатар хот

Үндсэн мэргэшил олгох тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дах хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.9 дэх заалт, Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/337 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар батлагдсан “Мэргэшүүлэх болон тасралтгүй сургалт зохион байгуулах, сургалт эрхлэх байгууллагыг сонгох, зөвшөөрөл олгох, сунгах, хүчингүй болгох журам”-ын 18.17, 19.3 дах заалт, Эрүүл мэндийн хөгжлийн төвийн ерөнхий захирлын 2020 оны А/12 дугаар тушаалаар баталсан шалгалтын комиссын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Төгсөлтийн дараах үндсэн мэргэшлийн сургалтын төгсөлтийн улсын давтан шалгалтад тэнцсэн 2 их эмчийн нэр, мэргэшил, үнэмлэхийн дугаарыг хавсралтаар баталсугай.


2. Дор дурдсан арга хэмжээг авч ажиллахыг Эрүүл мэндийн хөгжлийн төвийн ерөнхий захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Б.Нарантуяа/-д үүрэг болгосугай:

2.1 Төгсөгчдөд хавсралтын дагуу мэргэшлийн үнэмлэх баталгаажуулж олгох;

2.2 Нэр бүхий 2 их эмчид үндсэн мэргэшлийн үнэмлэх олгосон тухай мэдээллийг эрүүл мэндийн ажилтны мэдээний нэгдсэн санд бүртгэх, Эрүүл мэндийн хөгжлийн төвийн цахим хуудаст байршуулж нийтэд мэдээлэх.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Эмнэлгийн мэргэжилтний хөгжлийн зөвлөлийн дарга /Я.Амаржаргал/-д даалгасугай.


САЙД



Д.САРАНГЭРЭЛ

141200594

Эрүүл мэндийн сайдын  
 2020 оны 09 сарын 04 өдрийн  
 А/1122... дугаар тушаалын хавсралт



**Төгсөлтийн дараах үндсэн мэргэшлийн сургалтын төгсөлтийн давтан шалгалтад  
 тэнцсэн эмнэлгийн мэргэжилтний нэр, мэргэшил, үнэмлэхийн дугаар**

| № | Эцэг/эхийн нэр | Нэр         | Регистрийн дугаар | Захиалагч байгууллага                        | Элссэн тушаалын дугаар | Үндсэн мэргэшлийн чиглэл | Үнэмлэхийн дугаар   | Төлбөрийн хэлбэр | Сургалт эрхлэх байгууллага           | Онолын шалгалтын дүн | Дадлага шалгалтын дүн | Ерөнхий дүн |
|---|----------------|-------------|-------------------|--|------------------------|--------------------------|---------------------|------------------|--------------------------------------|----------------------|-----------------------|-------------|
| 1 | Баатарржав     | Бадамцэцэг  | ПБ89080861        | Ховд, Булган сумын Нэгдсэн эмнэлэг           | 2017.10.18 А/185       | Арьс судлал              | S(r)0912-02/2020/01 | Хувийн зардал    | Арьсны өвчин судлалын үндэсний төв   | 97                   | 80                    | 88.5        |
| 2 | Батсайхан      | Нандинболор | КЛ91111801        | Нийслэлийн "Мандам" өрхийн Эрүүл мэндийн төв | 2017.10.18 А/185       | Халдварт өвчин судлал    | S(r)0912-16/2020/01 | Хувийн зардал    | Халдварт өвчин судлалын үндэсний төв | 96                   | 86.5                  | 91.25       |